

БОДСАДВЫН ГУЧИН ДОЛООН ГАРЫН АВЛАГА

Жалсрай Тогмэдсанбо

Логишура дор мөргөмүй

Алинаар юмс бүгдийг ирэх, одох үгүйд болгоовч
Амьтны тусад нэгэн дор хичээнгүйг зохиогч
Ариун дээд багш хийгээд итгэл Жанрайсигт
Ашид гурван үүдний бишрэлээр мөргөмүй!

Тус, амгалан гарахуйн орон Туулсан бурхад
Дээдийн номыг бүтээснээс гардаг нь
Түүний гарын авлагыг мэдэхээс харгалзах тул
Бодьсадвын гарын авлагыг номлосугай!

1. Чөлөө, учралын их онгоцыг олсон энэ цагт
Өөрийг ба бусдыг орчлонгийн далайгаас
Өнөд гэтэлгэхийн тулд өдөр, шөнөд үл алгасарч
Сонсох, санах, бясалгах нь,
Бодьсадвын гарын авлага мөн
2. Садангийн зүгт шунал ус мэт хөлбөрдөг,
Дайсны зүгт уур хилэн гал мэт бадардаг,
Авах, гээхийг умартсан мунхагийн харанхуй
Аавын нутгийг тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
3. Муу нутгийг тэвчсэнээр нисваанис дараалан хорогдох ба
Сэтгэлийн алгасрал үгүй тул буяны үйл аяндаа арвидаж
Тунгалаг ухаанаар номд баттай мэдэл төрүүлдэг
Тухт аглагийг шүтэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
4. Янаг садантай өнөд ханилсан ч хагацдаг
Ядарч олсон эд баялагаа орхин үлдээдэг
Биеийн буудлыг сэтгэлийн зочин хаядаг
Энэ насыг орхих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
5. Нөхөрлөвөөс гурван хор арвидаж
Сонсох, санах, бясалгах нь доройтох ба
Асрал хийгээд энэрлийг үгүй хийдэг

Аюулт муу нөхдийг тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн

6. Эрхэм нэгнийг шүтвээс гэм барагдаж,
Эрдмийг шинийн саран мэт арвидуулдаг
Энэ л буяны садныг өөрийн биеэс ч илүү
Эрхэмлэн дээдлэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
7. Өөрөө орчлонгийн гянданд хүлэгдчихээд
Өөр бусдыг аварч чадах уу ертөнцийн тэнгэрүүд
Чухам иймээс хуурмаггүй авардаг
Чухаг дээдэд итгэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
8. Хүлцэхүйеэ бэрх муу заяаны зовлонг
Хилэнцэт үйлийн үр хэмээн Бурхан номлов, тиймээс
Хилэнцэт үйлийг аминд тулсан ч
Хэзээд үл үйлдэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
9. Аливаа ертөнцийн жаргал өвсний шүүдэр мэт
Ахархан хормын төдийд үгүй болдог жамтай
Өнөд үл хувирах гэтлэхүйн дээд хутагийг
Үргэлж чухалчилах нь,
Бодьсадвын гарын авлага мөн
10. Орчилгүй эхлэлээс намайг энэрсэн
Олон эхүүд зовбоос өөрийн жаргалаар яанам
Тиймийн тул, тоолшгүй амьтдыг гэтэлгэхийн тулд
Бодь сэтгэлийг төрүүлэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
11. Өөрт жаргал хүссэнээр зовлон л гардаг
Өрөөлд туслах сэтгэлээс Бурхад мэндэлдэг, тиймээс
Өөрийн жаргалыг бусдын зовлонгоор
Үнэнхүү солих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
12. Хэн нэгэн шуналын эрхээр эд, эрдэнэ
Хэрэгтэй бүхнийг минь булаан авсан ч
Бие хийгээд эд, гурван цагийн буянаа
Хэзээд түүнд зориулах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

13. Өөрт гэм өчүүхэн ч үгүй бөгөөтөл
Өрөөл бусад толгойг минь тасдавч
Өршөөл нигүүлслээр түүний хилэнцийг
Өөртөө авах нь,
Бодьсадвын гарын авлага мөн
14. Хэн нэгэн надад элдэв муу үгсийг
Хэлж ертөнц дахинаа түгээвч
Асрахуйн сэтгэлээр түүний эрдмийг
Алдаршуулан өгүүлэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
15. Олны дунд зарим нэгэн
Элдэв гэмийг минь уудлан, мууг өгүүлвээс
Эрхэм түүнийг буяны садан багш хэмээгээд
Эгнэгт хүндэтгэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
16. Хүү шигээ энхрийлж, тэтгэсэн нэгэн
Хүйтэн дайсан мэт намайг үзэн ядсан ч
Өвчинд нэрвэгдсэн хүүгийн эх мэт
Үлэмж энэрэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
17. Өөртэй адил, эсвээс дорд нэгэн
Омгийн эрхээр доромжлохыг оролдов ч
Оройн дээд багш мэт дээдэлж
Оройдоо залах нь,
Бодьсадвын гарын авлага мөн
18. Амьдрал ядуу ба бусдад басамжлуулж,
Адаар хорлогдож, хүчир өвчинд нэрвэгдсэн ч
Амьтан бүгдийн хилэнц, зовлонг өөртөө авахаас
Айж үл шантрах нь,
Бодьсадвын гарын авлага мөн
19. Нэр алдар түгж, олон амьтан бөхийж
Намсрайн эрдэнэ адилаг олсон ч
Орчлонгийн цог учралыг шимгүйд үзээд
Омоггүй байх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
20. Дотоод хилэнгийн дайснаа эс номхотговоос

Гадаад дайсныг даравч арвидна, тиймээс
Асрахуй хийгээд нигүүлсэхүйн цэргээр
Аюулт сэтгэлээ номхотгох нь,
Бодьсадвын гарын авлага мөн

21. Хүслийн эрдэм шорвог ус лугаа
Хичнээн эдлэвч шунал улам арвидна
Тиймийн тул, шунал төрүүлэгч эд бүгдийг
Тэр даруйд тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
22. Ямарчлан үзэгдэж буй бүгд өөрийн сэтгэл,
Сэтгэл нь угаас цацралын хязгаараас хагацсан
Түүнийг мэдсэнээр орон, барихуйн тэмдэгийг
Сэтгэлдээ үл үйлдэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
23. Сэтгэлд тааламжит зүйлтэй учиравч
Үзэгдэх нь зуны солонго лугаа
Үзэсгэлэнтэй ч үнэнд үл тооцож
Шунал тачаалыг тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
24. Элдэв зовлон зүүдэнд үхэх хүү мэт
Эндүү үзэгдлийг үнэнд баримталваас арвидна
Иймийн тул, таагүй нөхцөл учрах үест
Эндүүрэл хэмээх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
25. Гэгээрлийн төлөө биеэ ч өгөх хэрэгтэй бол
Гэр, эд зүйлсийг хэлэх хэрэг юун, тиймээс
Үр, хариу үл горилох
Өглөг өгөх нь,
Бодьсадвын гарын авлага мөн
26. Санвааргүйгээр өөрийн хэрэг үл бүтэх атал
Бусдын хэрэг бүтээхийг хүсэх нь инээдийн орон
Тиймийн тул, орчлонд үл дурших
Санваар сахих нь,
Бодьсадвын гарын авлага мөн
27. Хотол буяны эдийг хүсэгч бодьсадвад
Хорлол бүхэн эрдэнийн сан адил болой
Тиймийн тул, бусадтай үл мөчөөрхөх

Хүлцэнгүйг дадуулах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

28. Хичнээн өөрийн тусыг бүтээгч ширвага, брадига ч
Хичээж толгойн галыг унтраахыг хараад
Амьтан бүгдийн тусад эрдэм гарахуйн орон
Асар хичээнгүйд шамдах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

29. Амирлан оршихуй машид төгөлдөр үлэмж үзлээр
Аюулт нисваанисыг сайтар дардагийг мэдсэнээр
Дүрсгүй дөрвөөс үнэнхүү хэтэрсэн
Дияаныг бясалгах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

30. Билгүүнгүй аваас чинадад хүрсэн бусад таваар
Бурханы хутагийг олж үл чадах тул
Уран аргаар гурван зүйлийг үл атглах
Ухаан билгийг бясалгах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

31. Өөрийн эндүүрлийг өөрөө эс шинжвээс
Номын дүртэн ном бусыг ч үйлдэх тул
Үргэлжид өөрийн эндүүрлийг шинжилж
Өнөд тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн

32. Нисваанисын эрхээр бусад бодьсадва нарын
Гэмийг өгүүлвээс өөрөө доройтох тул
Гэтлэхүйн их хөлгөнд орших бодьгалын
Гэмийг үл өгүүлэх нь,
Бодьсадвын гарын авлага мөн

33. Олз, хүндлэлийн төлөө харилцан тэмцэлдэж
Сонсох, санах, бясалгахыг дордуулдаг тул
Садангийн ба өглөгийн эзний гэрт
Самуурч шунахыг тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн

34. Ширүүн үг бусдын сэтгэлийг хямрааж
Бодьсадвын явдал ёсыг доройтуулах тул
Бусдын сэтгэлд тааламжгүй
Ширүүн үгийг тэвчих нь,
Бодьсадвын гарын авлага мөн

35. Нисваанис дадваас ерөндөгөөр дарахад бэрх тул
Санамсарын бодьгал ерөндөгийн мэсийг барьж,
Самуун тачаал тэргүүтнийг төрсөн даруйд
Сайтар дарах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

36. Товчилвоос, аливаа явдал мөр юуг үйлдэвч
Өөрийн сэтгэл ямар мэт буй хэмээгээд
Үргэлж санамсар, мэдэмсэрээр
Өрөөлийн тусыг бүтээх нь,
Бодьсадвын гарын авлага мөн

37. Тэр мэт хичээн бүтээсэн буян бүгдээ
Тоолшгүй олон амьтдын зовлонг арилгахын тулд
Гурван зүйл машид ариун билгүүнээр
Бодийн хутагт зориулах нь,
Бодьсадвын гарын авлага мөн

Суут дээдсийн айлдварыг даган
Судар, дандар, шастирт зарлигласан утгыг
Бодьсадвын гучин долоон гарын авлага болгож
Бодьсадвын мөрд суралцахыг хүсэгчдийн тусад зохиовой

Мэргэн ухаан үгүй, суралцсан минь өчүүхэн тул
Мэргэдийг баясгах эвлүүлэг найруулга үгүй, гэвч
Эрхэм дээдсийн зарлиг ба сударт түшиглэсэн учир
Эндүүгүй бодьсадвын авлага мөн хэмээн сэтгэмүй

Дээд бодьсадвын агуу их явдал нь
Дорд ухаант надад хэмжихүйеэ бэрх тул
Харшлах, үл авцалдах зэрэг гэм бүрийг
Хүлцэн соёрх, дээдсүүд минь!

Үүнээс гарсан буянаар амьтан бүхэн
Үнэмлэхүй ба харьцангуй бодийн дээд сэтгэлээр
Сансар ба нирвааны хязгаарт үл орших
Сайвар ажирсан итгэл Жанрайсиг лугаа болтугай!

хэмээх үүнийг бусдын тусын тулд эш хийгээд ухааныг
өгүүлэгч тойн Тогмэд бээр Үлчүгийн эрдэнийн агуйд найруулвай.